

2019 он 8 сар 16 өдөр

Дугаар 19/12

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйл, СЗХ-ны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батласан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”-ыг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн эчнээ санал хураалт явуулах тухай 19/11 тоот тогтоолд дараах өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:

1. Тогтоолын 2-р зүйлд “Эчнээ санал хураалтад оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 8 сарын 31-ний өдрөөр тогтоосугай” гэж өөрчлөх,

2. Тогтоолын 4-р зүйлд “Эчнээ санал хураалтыг 2019 оны 9 дугаар сарын 2-ны өдрөөс 2019 оны 10 дүгээр сарын 11-ний өдөр хүртэл явуулсугай” гэж өөрчлөх,

3. Тогтоолын 7-р зүйлийг бүхэлд нь хүчингүйд тооцож, дараах байдлаар өөрчлөх. Үүнд: “Дараах нэр бүхий хүмүүсийг эчнээ санал хураалтын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга:

Глобал Дийл ХХН-ийн хуульч Баяржаргал овогтой Мөнхзул

Тооллогын комиссын гишүүн:

Глобал Дийл ХХН-ийн хуульч Нарантуяа овогтой Оролжмаа

4. Тогтоолд “Эчнээ саналын хуудас, эчнээ санал хураалтаас гарах шийдвэрийн төсөл, танилцуулга зэрэг холбогдох баримт бичгийг бэлэн болгож, 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн дотор үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.” гэсэн заалт нэмэх

5. Тогтоолд “Саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд саналын хуудас болон холбогдох баримт бичгийг 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Холдингсын байрны 2 давхар болон үнэт цаасны компаниудаар дамжуулан танилцуулсугай” гэсэн заалт нэмэх,

6. Тогтоолд “Хувьцаа эзэмшигчдээс эчнээ саналын хуудсыг 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 16.00 цаг хүртэл Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Холдингсын байрны 2 давхарт хүлээн авч, эчнээ санал хураалт явуулсугай” гэж нэмэх

7. Тогтоолын өөрчлөлтийг холбогдох байгууллагуудад мэдэгдэж, эчнээ санал хураалтыг зохион байгуулахыг Зохион байгуулах комиссын дарга Ч.Ганхуягт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



П.БАТБАЯР